


БНСУ-ын ДАТА АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОСИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

- I Өнөөгийн нөхцөл байдал
- II БНСУ дахь дата аж үйлдвэрлэлийн өнөөгийн байдал
- III БНСУ-ын дата аж үйлдвэрлэлийн салбарын гол асуудлууд
- IV БНСУ-ын мэдээллийн бодлого, хууль эрх зүйн тогтолцоо

I Өнөөгийн нөхцөл байдал

01 Нөхцөл байдал



Төлөв 1. Өгөгдлийн үнэ цэнэ ба чанар сайжирсан

- Өгөгдлийн үнэ цэн өссөн
- Чанарын дэмжлэг үзүүлсэн

Төлөв 2. Өгөгдөл хуваалцах / түгээлт нэмэгдсэн

- Засгийн газар, корпорациуд, эмнэлэг, судалгааны байгууллага хооронд мэдээлэл солилцох хүртээмж нэмэгдсэн

Төлөв 3. Глобал мэдээллийн хамтын ажиллагаа

- Олон улсын хамтын ажиллагаа, дэвшил гарсан

Төлөв 4. Жижиг, дунд өгөгдлийн зах зээлийг идэвхжүүлэх

- Дотоодын жижиг, дунд, гарааны бизнесүүдийн зах зээлийн оролцоог дэмжсэн

Төлөв 1. EU (European Union)

- Дижитал зах зээлийн хууль

Төлөв 2. GDPR (General Data Protection Regulation)

- Мэдээллийн бүрэн эрхт байдал

Төлөв 3. Бие даасан улс орнууд


- Өгөгдлийг нутагшуулах / эрх, хувийн мэдээлэл

II БНСУ дахь дата аж үйлдвэрлэлийн өнөөгийн байдал



02 БНСУ дахь дата аж үйлдвэрлэлийн өнөөгийн төлөв байдал

▶ БНСУ-ын дата аж үйлдвэрлэлийн бодлого, хууль эрх зүйн тогтолцоо







02 БНСУ дахь дата аж үйлдвэрлэлийн өнөөгийн төлөв байдал

Өгөгдлийн аж үйлдвэрлэлийн зах зээлийн төлөв байдал


ӨГӨГДЛИЙН АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЦАР ХҮРЭЭ



ӨГӨГДЛИЙН АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОРЛУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ



ӨГӨГДЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ



Салбарын тулгамдсан асуудлууд



- Боловсон хүчин **197,802** **м**
- Өмнөх жилээс **9.4%** өссөн
- Дараагийн 5 жилд шаардлагатай боловсон хүчин **25,298** **хүн** таамаг
- Боловсон хүчний дутагдал **11.3%**
- Онцлох мэргэжлийн дутагдал

Өгөгдөл сулдаач
31.5 %

Өгөгдөл хөгжүүлэгч
14.0 %

Өгөгдөл шинжээч
13.7 %

III БНСУ-ын дата аж үйлдвэрлэлийн гол асуудлууд

03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

Мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргаар олж мэдэх

**2023 БНСУ-ЫН ДАТА АЖ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АСУУДЛУУД**

TOP 6



03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

▶ Асуудлыг шинжлэх арга зүй

Дата цуглуулах тойм

- Цуглуулгын зорилт: Еолон нийтийн хэвлэл, мэдээллийн технологийн сэтгүүл, засгийн газрын хэвлэл мэдээлэл “Дата” гэсэн түлхүүр үгийг агуулсан нийтлэлүүд
- Цуглуулах хугацаа: 2022.10 ~ 2023.09
- Цуглуулгын тоо: 32,764





03 Солонгосын дата салбарын гол асуудлууд



Асуудал 1) мэдээллийн сургалтад суурилсан үүсмэл хиймэл оюун ухааныг хөгжүүлэх үйл ажиллагаа [1/2]

Онцлох компаниуд үүсмэл хиймэл оюуны технологийг ашигласан үйлчилгээний хөгжлийг хурдасгав



- Өгөгдөл хадгалах, боловсруулах технологийн өндөр дэвшилтийн хүрээнд олон төрлийн, мөн төрөл бүрд эсрэг өгөгдлийг сургаж, **бичвэр, зураг, дуу хоолой** зэрэг шинэ өгөгдлийг бүтээх **үүсмэл "Generative AI"** технологийг маш идэвхтэйгээр ашиглаж байна.
- Ялангуяа 700 тэрбум өгөгдлийн токеныг урьдчилан сурсан хэмээн мэдэгдэж байгаа Open AI-ийн **Chat GPT** танигдсанаас хойш үүсмэл хиймэл оюун ухааны зах зээлийн өрсөлдөөн эрчимжиж байна.
- Солонгост мөн адил олон тооны компаниуд үүсмэл хиймэл хиймэл оюун ухааныг ашиглан шинэ үйлчилгээг хөгжүүлэх үйл хэрэг хуртай нэмэгдэж байгаа бөгөөд түүнийг хангах өндөр чанартай өгөгдлийг олж авах өрсөлдөөн ч улам бүр эрчимжиж байна.

ААН	Технологийн нэр	Агуулга
NAVER	HyperCLOVA	<ul style="list-style-type: none"> • Солонгос хэлний тусгай загвар (Солонгос хэлийг ChatGPT-ээс 6500 дахин их сурсан гэж мэдээлсэн) • Өөрийн үүсгэсэн хиймэл оюун ухаанаар хэрэглэгчдэд (компаниудад) өөрсдийн өгөгдлийн багцыг ашигласан тусгайлан тохируулсан үйлчилгээ үзүүлдэг.
LG	EXAONE 2.0	Солонгос, англи хэлээр ойлголцож, хариулж чаддаг хос хэлтэй загвар, текст болон зургаар мэдээлэл солилцох олон төрлийн загварын чадвартай ба патент, десертац зэрэг 45 сая орчим мэргэжлийн ном товхимол болон 350 сая зурагийг урьдчилан судалсан.
KT	Mi:dm	Том хэмжээний өгөгдлийг урьдчилан судалж олон төрлийн сэдвээр AI үйлчилгээг үүсгэх чадвартай суурь загвар ба өмнөх AI загваруудыг хязгаарлах асуудал болох их хэмжээний сургалтын мэдээлэл цуглуулах болон судлах хугацааг богиносгож байгаа юм
SKT	A.	Дотооддоо хөгжүүлж буй "том хэлний загвар" (LLM)-ийг сайжруулснаар Adot нь богино хариулттай харилцан яриа бус хэрэглэгчийн нөхцөл байдлыг ойлгож, илүү нарийн төвөгтэй санааг ойлгох боломжтой
Samsung SDS	Brity Copilot / FabriX	Үүсмэл хиймэл оюун ухаан ашиглан төрөл бүрийн үйлдлийг автоматжуулах дотоод шийдэл · өмнөх системүүдтэй холбогдож, хувийн үүлэн орчныг дэмждэг, өндөр аюулгүй байдлыг хангасан (*2024 онд гарсан)



03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

Асуудал 1) Өгөгдлийн сургалтад суурилсан үүсмэл хиймэл оюун ухааныг хөгжүүлэх үйл ажиллагаа [2/2]

Засгийн газар, мэдээлэл ба хиймэл оюун ухааныг тогтвортой ашиглах стратеги боловсруулав

- Үүсмэл хиймэл оюун ухаан нь бизнесийн олон боломжуудыг санал болгож байгаа хэдий ч өгөгдөл, мэдээлэл алдагдах, хэт хуурамч мэдээлэл, зохиогчийн эрхийн асуудал, буруу ойлголт, буруу үүсгэсэн контент зэрэгт **шийдвэрлэх шаардлагатай ёс суртахуун, технологийн асуудлууд** байсаар байна.
- Иймээс засгийн газар нь мэдээллийн хүртээмжийг хангах, дижитал бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх, тоон ялгааг арилгах зэрэг заалтуудыг багтаасан **"Дижитал эрхийн барим бичиг"**-ийг танилцуулав.

'AI Data Convergence Network'-ийг эхлүүлэв. 2023.09.08	БНСУ-ын mega-AI үсрэнгүй хөгжлийн төлөвлөгөө 2023.09.13	Хүн амын хиймэл оюун ухааныг өдөр тутмын хэрэглээг нэвтрүүлэв 2023.09.13	"Дижитал эрхийн барим бичиг"-ийг танилцуулав 2023.09.25
Аж үйлдвэрийн бүх салбарт хиймэл оюун ухааны ашиглалтыг нэмэгдүүлэх	Салбар бүрээр төрөлжсөн чөлөөт хяналтын хүснэгт, хөгжүүлэлтийн гарын авлага нэмэгдүүлэх	Салбар бүрээр төрөлжсөн чөлөөт хяналтын хүснэгт, хөгжүүлэлтийн гарын авлага нэмэгдүүлэх	Шинэ дижитал дэг журмын үндсэн чиглэл хангах
AI программын үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн салбарын өгөгдлийг олж авах	Эрсдлийн хүчин зүйлс, гүйцэтгэлийг гуравдагч этгээдээр үнэлүүлэх	Эрсдэлийн хүчин зүйлс, гүйцэтгэлийг гуравдагч этгээдээр үнэлүүлэх	Дижитал хурцдалд засгийн газраас авах эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
Их хэмжээний үгийн сан бүхий 30 тэрбум токен бүтээхээр төлөвлөгөө	Хэт том хиймэл оюун ухааны хязгаарлалтыг даван туулах технологийг хөгжүүлэх	итгэлцлийн баталгаажуулалтын системийг бий болгох	Хүн бүр чөлөөтэй хэлэлцэх боломжтой “цахим нийтийн форум” байгуулах
	Хагас дамжуулагч, платформ, МХХТ-ийн дэд бүтцийг уялдаа хамтын ажиллагааг бий болгох	Хэт том хиймэл оюун ухааны хязгаарлалтыг даван туулах технологийг хөгжүүлэх	Эрдэмтэд, үйлдвэрлэгчид, хэрэглэгчийн оролцоотой төр, хувийн хэвшлийн зөвлөл байгуулах



03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

Асуудал 2) "хэт хувийн шинж"-тэй хөдөлгүүр болгон ашиглах нь

Мэдээлэлд суурилсан хэт хувийн шинжтэй үйлчилгээнүүдийг өргөжүүлэн сайжруулах нь



мэдээлэл ба хиймэл оюун ухаанд суурилсан **захиалгат үйлчилгээ** нь хувь хүний өдөр тутмын хэрэглээ болсоор байгаа ба компаниуд хэрэглэгчидтэйгээ илүү ойртох хүчин чармайлтыг гаргасаар байна. Хэрэглэгчийн хуримтлагдсан мэдээлэл дээр үндэслэн **"зорилтот" стратеги** ба **"хэт хувь хүний" технологийг** ашиглаж байна. Үүний үр дүнд өдөр тутмын амьдралтай нь нягт холбоотой хэт хувийн шинжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд хөгжиж байна.

Baedal Minjok | Хоол хүргэлт
Оршин суугчдын судалгаа, зочилсон түүх зэрэгт зан төлөвт дүн шинжилгээ хийж хувийн хоолны цэс санал болгох AI үйлчилгээ үзүүлж байна



CJ Well Care : эрүүл хооллолт
Хувь хүний хувийн амьдралын хэв маяг, өгөгдөлд үндэслэн эрүүл хоол хүнсийг санал болгох, шинэ бүтээгдэхүүн гаргах




Naver : Онлайн худалдаа
Худалдаан авалтын түүхэнд дүн шинжилгээ хийж, бүтээгдэхүүний зөвлөмжийг харуулан сонирхлыг тамгалж бараа санал болгох



Lotte Healthcare : эрүүл мэндийн удирдлага
Эрүүл мэндээ удирдах хувийн платформ ашиглах, эрүүл мэндийн хувийн гарын авлага, эрүүл мэндийн хоолны дэглэм санал өгөх



WeMakePrice : Цахим худалдаа
230,000 худалдааны төвийн 700 сая бүтээгдэхүүнээс гаргаж авсан өгөгдлийг ашиглан "хэт хувийн" үйлчилгээ санал болгох.



Солонгосын аялал жуулчлалын агент
Их өгөгдлийг ашиглан хэрэглэгчдэд дотоодын аялал жуулчлалын маршрут, бүс нутгуудын аяллын газруудыг бодит цаг хугацаанд нь өгдөг



Hyundai Engineering & Construction
Орон сууцны хиймэл оюун ухааны эрүүл мэндийн платформ нь бодит амьдрал болон дотоод орчны өгөгдөлд дүн шинжилгээ хийх замаар эрүүл мэндийн удирдлагын хувийн шийдлийн санал



Amore Pacific : Захиалгат гоо сайхан
хүн бүрийн арьсны нөхцөл байдалд шууд дүн шинжилгээ хийж, арьсны төрөл, амьдралын хэв маяг, онцлогт тохирсон урьдчилан үүсгэж бүтээгдэхүүн үйлдвэрлэх



NuVilab : цавхави бэхүүлэх
Өдөр өнжүүлэх төвд хооллох дэглэмийг сайжруулан хиймэл оюун ухааны хоол тэжээлийн технологийн үйлчилгээг үзүүлэх





03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

Асуудал 3) Эрүүл мэнд, эмнэлгийн салбарт өгөгдлийн ашиглалтыг бүрэн идэвхжүүлсэн [1/2]

Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн нэмэлт өөрчлөлт ба “My Data” зураглал

- Мэдээлийн аюулгүй, идэвхтэй хэрэглээг идэвхжүүлэх хөдөлгөөн нэмэгдэж байна.
- Ялангуяа хувийн нууц мэдээлэл их агуулдаг эрүүл мэндийн салбарт **мэдээллийн аюулгүй хэрэглээнд** тулгуурласан олон нийт үр өгөөжийг нь хүртэх талд бодлогын янз бүрийн арга хэмжээ авч байна.
- 2023 оны 3-р сард **"Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль"**-ийг шинэчлэн баталснаар эмнэлгийн үйлчилгээ зэрэг бусад бүх салбарт "Миний мэдээлэл" үйлчилгээний нэмэгдэх шалтгаан болсон хувийн мэдээллийг дамжуулах хүсэлт гаргах эрх шинэчлэгдсэн.
- Засгийн газар "Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль"-ийн холбогдох салбар хуулиудыг энэ ондоо багтаан боловсруулж, 2025 оноос бодитоор хэрэгжүүлэхээр төлөвлөж байна..

Хувийн нууц мэдээллийг ашиглах миний мэдээллийн зураглал





03 Солонгосын дата салбарын гол асуудлууд




Асуудал 3) Эрүүл мэнд, эмнэлгийн салбарт өгөгдлийн ашиглалтыг бүрэн идэвхжүүлсэн [2/2]

Улсын хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлын бүсийг өргөжүүлэх нь

- Мэдээллийг алдагдуулахгүйгээр найдвартай задлан шинжлэх, ашиглах боломжтой **“дата аюулгүй бүс”** өргөжин тэлсээр байна.
- Онцгойлон төвийн "Тэжонг аюулгүй бүс" нь төвийн бүсийн **судалгааны болон эмнэлгийн байгууллагуудтай хамтран** ашиглалтын явцын тохиолдлыг илрүүлж байна
- Түүнээс гадна эрүүл мэнд, эмнэлгийн мэдээллийг аюулгүй ашиглах боломжтой Чүнчон **“мэдээллийн аюулгүй бүс”-ийг** хамруулан энэ ондоо нэмж 5 аюулгүй бүсийг нэмж байгуулна.
- Ингэснээр хэрэглэгчид өндөр чанартай мэдээлэлд хандах боломжтой **хангамжийн бааз, хамтын ажиллагааны систем** өргөжих төлөвтэй байна.

Дотоодын томоохон мэдээллийн аюулгүйн бүсүүд



БНСУ-ын мэдээллийн аж үйлдвэрийг дэмжих агентлаг. (Сөүл хот)

БНСУ-ын хурдны замын корпорац (Соннам хот)

БНСУ-ын Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын хүнсний боловсрол, соёлын мэдээллийн хүрээлэн (Сэжун хот)

БНСУ-ын Жооллабук-догийн үндэсний тэтгэврийн алба (Жонжу хот)

БНСУ-ын цахилгаан эрчим хүчний корпорац (Нажу хот)

2023 оны 10 сарын байдлаар



03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

Асуудал 4) мэдээлэлд суурилсан, сүүлийн үеийн хөдөлгөөнт тээврийн салбарын өсөлт 1/2]

Мэдээлэлд суурилсан автомашин үйлдвэрлэлийн салбарын хөгжил



Автотээврийн салбарт өгөгдөлд суурилсан дижитал хувьсалт хурдацтай хөгжиж байна. Ялангуяа автомашин үйлдвэрлэл бүхэлдээ **программ хангамж төвтэй тээврийн хэрэгсэлд (SDV)** шилжиж байгаа ба мэдээллийн үнэ цэнэ өссөөр байна. Автомашин үйлдвэрлэгч болон программ хангамжийн компаниуд ирээдүйн автомашин үйлдвэрлэлтийн салбарыг тэргүүлэхийн төлөө бие даасан жолоодлогын системийн загвар, үйлчилгээг үзүүлэхийн тулд өгөгдөл цуглуулах, ашиглах чадварыг нэмэгдүүлэх талд бүх хүчин чармайлтаа гаргаж байна.

ААН	Холбогдох агуулга
Hyundai Motors & Kia	<ul style="list-style-type: none"> Hyundai, Kia компаниудын холбоот автомашины хэрэглэгчдийн тоог нэмэгдсэнээр замын хөдөлгөөний гэрлэн дохио, тээврийн хэрэгслийн мэдрэгч, замын мэдээлэл зэрэг хөдөлгөөнт тээврийн асар их өгөгдөл хуримтлагдсан байна. Өгөгдөл болон AI технологид суурилсан хөдөлгөөнт тээврийн үйлчилгээний дэвшлийг дэмжинэ
Hankook Tire	<ul style="list-style-type: none"> Дугуйны элэгдэл, даралт, температур, жолоодлогын мэдээлэл, жолоодлогын үед замын гадаргуугийн нөхцөл байдлыг суурилагдсан мэдрэгчээс цуглуулсан өгөгдөлд үндэслэн оношлох боломжтой Мэдээлэлд тулгуурлан аюулгүй жолоодлого, үр ашигтай тээврийн хэрэгслийн удирдлагыг хэрэгжүүлэх 'i-Tire'-ийг бүтээв
42 dot	<ul style="list-style-type: none"> Хотын тээврийн үйлдлийн системийг нэвтрүүлэх, замын хөдөлгөөний бодит өгөгдлийг баталгаажуулах, өгөгдөл ашиглах технологийг бодитойгоор ахиулахын тулд өгөгдөлд суурилсан хөдөлгөөнт платформын системийг бий болгох
Kakao Mobility	<ul style="list-style-type: none"> Цуглуулсан мэдээлэлд үндэслэн өөрийн тээврийн удирдлагын системийг (TMS) хангана Өгөгдлийн шинжилгээнд үндэслэн такси/зогсоол/дуудлагын жолоочийн эрэлт хэрэгцээг урьдчилан таамаглах, хэрэглэгчийн тав тухыг сайжруулах
T Map Mobility	<ul style="list-style-type: none"> Навигаци болон нийтийн тээврийн мэдээллийг нэгтгэн хөгжүүлж супер программ болох 'All New T Map'-ийг гаргасан Жилд дунджаар 4.4 тэрбум ажиллагаа 22 жилийн замын мэдээллийн хуримтлалд үндэслэн LLM боловсруулсан
Socar	<ul style="list-style-type: none"> Цуглуулсан мэдээлэлд үндэслэн эрэлтийг урьдчилан таамаглаж, оновчтой үнийг тогтоодог "Динамик үнийн тогтолцоо" системийг боловсруулсан дотоод мэдээлэл хуваалцах систем 'Soca Data Market' -аар дамжуулан өгөгдөл тооцооллын стандарт болон нэгтгэлийн статусыг хуваалцах
Электроник, харилцаа холбооны судалгааны хүрээлэн гэх мэт.	<ul style="list-style-type: none"> Өгөгдөл, сүлжээ, хиймэл оюун ухаан (DNA)-ийг дронтой хослуулан технологийг хөгжүүлж, нисгэгчгүй хөлгийн өгөгдлийг бодит цаг хугацаанд дамжуулах, хиймэл оюун ухаанаар дүн шинжилгээ хийх чадвартай DNA + дрон платформыг бий боловсруулсан. Платформд суурилсан уралдаант дамжуулалтын үйлчилгээ (Самюг их сургуулийн бодит цагийн замын гэмтэл илрүүлэх, Кюнпүүк их сургуулийн аюулгүй буцах үйлчилгээ гэх мэт) идвэхжсээр байна






03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

Асуудал 4) мэдээлэлд суурилсан, сүүлийн үеийн хөдөлгөөнт тээврийн салбарын өсөлт [2/2]

Мэдээллийг стандартчилснаар 2027 онд бүрэн бие даасан жолоодлогыг арилжаанд гаргана

- Засгийн газар бие даасан тээврийн хэрэгсэл хоорондын (V2V) болон тээврийн хэрэгсэл болон дэд бүтцийн хоорондын (V2I) харилцаг зохицуулах **V2X өгөгдлийн форматыг стандартчилсныг** зарлав. Мэдээллийн форматыг стандартчилснаар **тээврийн хэрэгслийн байршил, хурд, тоормос, гэрлэн дохионы** төлөв гэх мэт янз бүрийн мэдээллийг тээврийн хэрэгсэл хоорондоо солилцоно.
- Мэдээлэл стандартчилсанаар тээврийн хэрэгсэл нь зөвхөн бие даан жолоодлогыг хийх бус бүх мэдээллийн **хамтын ажиллагаанд суурилсан чөлөөт жолоодлогын** үндэс бүрдэж, түүгээр дамжин бие даасан жолоодлогын гүйцэтгэл, аюулгүй байдлыг сайжирна гэж найдаж байна.

Бие даасан тээврийн хэрэгслийн өгөгдөл тээврийн хэрэгсэл ба объект хоорондын холбоо (V2X).





03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

Асуудал 5) Өгөгдлийн чанарын удирдлагын хэрэгцээг ба өргөжүүлэлт [1/2]


Хиймэл оюуны эрин үеийн мэдээллийн чанарын удирдлагын хэрэгцээ

Өгөгдлийн чанар нь компаниудын хувьд маш чухал хүчин зүйл болж байна. Учир нь буруу мэдээлэл, чанар муутай өгөгдөл ашиглах нь өгөгдлийн дүн шинжилгээний үнэ цэнийг бууруулж, компанийн үзүүлж буй **үйлчилгээний чанарыг бууруулдаг**.

Ялангуяа хиймэл оюун ухааны хувьд сургалтын мэдээллээс шалтгаалж алдаа мадаг үүсэх тул алдаатай өгөгдлийг сургаснаас үүдэж ёс зүйн, эрх зүйн асуудлууд үүсэж болзошгүй. Тиймээс өгөгдлийн найдвартай хэрэглээг хангах зорилгоор **хувийн болон төрийн байгууллагуудад мэдээллийн чанар, ашиглалтын менежментийн үйл ажиллагаа** явуулж байна.

Мэдээллийн чанарын удирдлагын амьдралын мөчлөг

Мэдээлэл цуглуулахаас эхлээд дүн шинжилгээ хийх, суралцах, дүгнэлт гаргах, дүрслэх хүртэлх өгөгдлийн амьдралын мөчлөгийн туршид өндөр чанарыг хадгалахын тулд өгөгдлийн **чанарын удирдлагын тогтолцоог** нэвтрүүлэх ёстой.





03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

Асуудал 5) Өгөгдлийн чанарын удирдлагын хэрэгцээг ба өргөжүүлэлт [2/2]

Мэдээллийн чанарыг сайжруулах засгийн газрын хүчин чармайлт

Чанартай мэдээллийн түгээлтийг дэмжих талд засгийн газрын хүчин чармайлт үргэлжилсээр байна. Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн яамнаас "Өгөгдлийн үйлдвэрлэлийг дэмжих, ашиглах үндсэн хууль"-ийн дагуу өгөгдлийн чанарын баталгаажуулалт хийх байгууллагыг тогтоосон бөгөөд үүнийг дагаад мэдээллийн чанарын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, чанартай мэдээлэл үйлдвэрлэлийг дэмжих боломж болгон ашиглаж байна. Ингэснээр мэдээллийн хангамж, борлуулалтын зах зээл идэвхжих төлөвтэй байна.

Өгөгдлийн чанарын баталгаажуулалтын систем

Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн яамнаас гурван байгууллагыг мэдээллийн чанарын баталгаажуулалтын байгууллагаар томилсон ба "Өгөгдлийн аж үйлдвэрлэлийн тухай хууль"-ийн дагуу чанарын баталгаажуулалтын байгууллага нь өгөгдлийн агуулгын бүрэн бүтэн байдал, хүчин төгөлдөр байдал, үнэн зөвийг хянаж, мэдээллийн бүтцийн нийцтэй байдлыг шалгах ёстой. Мөн, өгөгдлийн удирдлагын системийн ашиглалт, хүртээмжийг шалгах шаардлагатай. Мэдээллийн чанарын баталгаажуулалтыг эдгээр чанарын стандартын дагуу хийх ёстой.



데이터품질인증
Certificate of Data Quality

Мэдээллийн чанарын
баталгаажуулалтын
байгууллага

CS Co., Ltd.

Wise Stone Co., Ltd.

Солонгосын Мэдээлэл, Харилцаа
Холбооны Технологийн Холбоо

Мэдээллийн чанарын баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэх




03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

Асуудал 6) мэдээллийн компаниудын глобалчлал [1/2]

Дижитал инновацийн компаниудад гадаадад зах зээлд дэмжлэг үзүүлэх

Дэлхийн зах зээлд тэргүүлэгч болгох **“К-Дижитал”**-ыг хэрэгжүүлэхийн тулд БНСУ-ын дижитал стратегид тулгуурлан төрийн дэмжлэг улам нэмэгдсээр байна. Тухайлбал, дотоодын дижитал компаниуд нь глобал компанируу шилжин орох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан экспортыг дэмжих тогтолцоог бий болгож байна. Загийн газар нь **"Дижитал экспортын нээн илрүүлэх баг"**-ийн үйл ажиллагаагаар дамжуулан номхон далай, ойрх дорнод, Америк зэрэг бүс нутагт хувийн хэвшлийн том ба дунд, жижиг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг нэгтгэх загваруудыг хайн илрүүлж, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэж байна. Шинжлэх ухаан, мэдээллийн технологийн яам нь дижитал инновацийн компаниудыг гадаад зах зээлд үйл ажиллагаагаа өргөжүүлэх талд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Глобал дижитал инновацийн сүлжээ (GDIN)”-ийг эхлүүлсэн. GDIN нь **"Дэлхийн дижитал замнал"**-ыг бий болгох зорилгын үүднээс дижитал өөрчлөлтийн эрэлт хэрэгцээ, дижитал зах зээлд хөгжих өндөр боломжтой хөгжиж буй зах зээлд компаниудыг үйл ажиллагааг эхлүүлэх, дэмжих боломжоор хангаж байна. Түүнчлэн Солонгос- номхон далайн бүс нутгийн дижитал сайд нарын уулзалт, дээд хэмжээний уулзалт зэрэг тухайн бүс нутгийн орнуудтай хиймэл оюун ухаан, өгөгдлийн уялдаа холбоог өргөжүүлэн тэлэх хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлж байна.



신호 · 선진시장 현지 디지털 기술수요 기반 판로개척

* Эх сурвалж: Дижитал инновацийн компаниудыг гадаадад өргөжүүлэх чиглэлээр мэргэшсэн байгууллага, дэлхийн дижитал замыг анхдагч, Шинжлэх ухаан, МХХТ-ийн яамны хэвлэлийн мэдээ, 2023 оны 9-р сар.



03 Солонгосын дата салбарын гол асуудлууд

▶ Асуудал 6) мэдээллийн компаниудын глобалчлал [2/2]

Датанд суурилсан дижитал компаниуд глобал зах зээлд гарч байна

Дэвшилтэт дата, хиймэл оюун ухаанд суурилсан дижитал шинэ технологи, үйлчилгээний салбарын дэлхийн зах зээлд гарч буй дотоодын компаниудын улам нэмэгдсээр байна.

ААН	Үйлчилгээ	Орсон ба зорилтот улс
Waycer	Хиймэл оюунд суурилсан ходоод гэдэсний дурангийн шийдэл, өвчтөний өгөгдөлд дүн шинжилгээ хийх платформ	Вьетнам
Lululab	Арьсны мэдээлэлд суурилсан гоо сайхан, эрүүл мэндийн шийдэл	Вьетнам
Robo Arete	Бодит үеийн хяналтын өгөгдөлд суурилсан оновчтой шарсан хоол хийх робот ба систем	АНУ, Сингапур
Rutten Technologies	Хэрэглэгчийн өгөгдөл дээр суурилсан текст үүсгэх AI шийдэл	Япон
Freewillin	Сургалтын өгөгдөлд (математикийн бодлого) суурилсан Edutech шийдэл	Япон, Зүүн өмнөд Ази
INTERX	Бие даасан үйлдвэрлэлийг дэмждэг хиймэл оюунд суурилсан үйлдвэрлэлийн өргөдлийн дүн шинжилгээний үйлчилгээ үзүүлэх платформ	Япон, Зүүн өмнөд Ази

IV БНСУ-ын мэдээллийн бодлого, хууль эрх зүйн тогтолцоо



04 БНСУ-ЫН МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО

1) Өгөгдлийн инноваци ба үндэсний бодлого

А. Солонгосын дижитал стратеги (2022.09) [1/2]

2022 оны 9 сард Засгийн газраас “Ард түмэнтэйгээ хамтдаа дэлхийн жишиг болох дижитал БНСУ” алсын хараан доор **“БНСУ-ын дижитал стратеги”**-ийг танилцуулсан.

Стратеги	Хэрэгжүүлэх сэдвүүд
Дэлхийн хамгийн шилдэг дижитал чадварууд	<ul style="list-style-type: none"> ① Технологийн давамгайлалд хариу үйлдэл үзүүлэх 6 төрлийн дижитал инновацийн технологийг бүрдүүлэх ② Хангалттай цахим нөөцийг бүрдүүлэх ③ Илүү хурдан, илүү аюулгүй сүлжээг бүрдүүлэх ④ 1 сая боловсон хүчнийг хөгжүүлснээр дижитал ажиллах хүчний хүчирхэг улс болох ⑤ Хил хязгаарыг давсан дижитал платформын аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх ⑥ Глобал зах зээлд тэргүүлэгч "K-digital"-ийг хэрэгжүүлэх
Өргөжин тэлж буй дижитал эдийн засаг	<ul style="list-style-type: none"> ① Үйлчилгээний салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх ② Ирээдүйн үйлдвэрлэлд дэвшил гаргах ③ Хөдөө аж ахуй, мал аж ахуй, загас агнуурын салбарын өсөлтийн шинэ хөдөлгүүр бүрдүүлэх
Хүртээмжтэй дижитал нийгэм	<ul style="list-style-type: none"> ① Илүү аюулгүй, тав тухтай амьдралын суурийн тавих ② Иргэн бүрд дижитал ашиг тусыг баталгаажуулах ③ Цахимаар дахин мэндлэх орон нутгийн нийгэм байгуулах
Хамтдаа хэрэгжүүлэх дижитал платформд засгийн газар	<ul style="list-style-type: none"> ① Инновацийн дэд бүтцийг бүрдүүлэх, мэдээллийн бүрэн нээлттэй байдал, ашиглалтыг дэмжих ② Хиймэл оюун болон өгөгдлийн технологид суурилсан засгийн газрын ажлын арга барил дахь инновац ③ Аюулгүй, найдвартай хэрэглээний орчиг хангах
Инновацилагдаж буй дижитал соёл	<ul style="list-style-type: none"> ① Хувийн хэвшил тэргүүлсэн дижитал инновацийн соёлыг бий болгох ② Инновацад саад учруулж буй зохицуулалтын шинэтгэл ба зөрчлийг тохируулах ③ Дижитал эдийн засаг, нийгмийн хууль тогтоомжийг бий болгох ④ Дижитал инновацийг дэлхий даяар түгээх



04 БНСУ-ын мэдээллийн бодлого, хууль эрх зүйн тогтолцоо

1) Өгөгдлийн инноваци ба үндэсний бодлого

А. Солонгосын дижитал стратеги (2022.09) [2/2]

Өгөгдлийн чадавхыг бэхжүүлэхийн тулд засгийн газраас хиймэл оюун ухаан, метаверс, кибер аюулгүй байдал зэрэг зургаан шинэлэг технологид эрчимтэй хөрөнгө оруулалт хийж байгаа ба хиймэл оюун ухаан, өгөгдөл, үүлэн тооцоолол, программ хангамж гэх мэт цахим нөөцийг бүрдүүлэхээр төлөвлөж байна. Мөн чанартай мэдээллээр хангаж өгөгдлийн үнэ цэнийг бодитой үнэлэх аргачлал ба системийг бүрдүүлж төр хувийн мэдээллийн платформын уялдаа холбо, "Миний мэдээлэл"-ийг нэмэгдүүлэх ажлууд хийгдэж байна.

Солонгосын дижитал стратеги дахь өгөгдөлтэй холбоотой сэдвүүд

(Нээлттэй) Чанартай өгөгдөл нийлүүлэх, ашиглах чадварыг сайжруулахад чиглэсэн хангамжийн системийг бүрдүүлэх

- AI сургалтын өгөгдлийн бүтцийг бүх салбарт өргөжүүлэх: Зам тээвэр, логистик гэх мэт 6 салбараас үйлдвэрлэл, соёл, аялал жуулчлал зэрэг олон салбарт өргөжүүлэн тэлэх.
- Байгууллагын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой асуудал шийдвэрлэх сан байгуулах: Жижиг, дунд бизнесүүдэд тулгарч буй ижил төстэй асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хиймэл оюун ухаанд суурилсан амжилт, бүтэлгүйтлийн тохиолдлуудыг цуглуулж, асуудал шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- AI хөгжүүлэгчдийн хэрэгцээг тусгасан нээлттэй интернэтийн өгөгдлийг цуглуулах, ханган нийлүүлэх: их өгөгдөл ашиглахад амар хялбар байдлыг нэмэгдүүлэхийн тулд зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийн өөрчлөлтийг хянан үзэх.

(Арилжаа) Өгөгдлийг үнэ цэнийг хүлээн зөвшөөрч, арилжааны эрин үеийг идэвхжүүлж байна.

- (үнэ цэний үнэлгээ) Өгөгдлийг бодитойгоор үнэлэх үнэлгээний арга зүй ба системийг бүрдүүлэх : Өгөгдлийн үнэлгээний системийг нэвтрүүлэх.
- (Чанарын баталгаажуулалт) Өгөгдлийн чанарыг сайжруулах чанарын ба стандартыг бүрдүүлэх : Өгөгдлийн чанарын баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэх.
- (Төлбөр тооцоо ба Нөхөн олговор) Мэдээлэл дамжуулах төлбөр, нөхөн олговрын системийг нэвтрүүлэх.
- (Хөрөнгийн хамгаалалт) Дата хөрөнгийг хамгаалах, буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх.
- (Ханган нийлүүлэх зарчим) Өгөгдлийн зохистой хуваарилалт, шударга ханган нийлүүлэлтийн зарчмыг бүрдүүлэх : Мэдээллийн маргааныг зуучлах хороо, стандарт гэрээ зэрэг нэвтрүүлэх
- (Дата худалдааны компани) Хэрэглэгч, ханган нийлүүлэгчдийн хооронд өгөгдлийн харилцааг зуучлах мэргэжилтэн бэлтгэх : Өгөгдөл арилжааны компанийн бүртгэлийн системийг нэвтрүүлэх, холбогдох сургалт гэх мэт.

(Уялдаа холбоо) Төр хувийн хэвшлийн мэдээллийн интеграцчлалаар хэмнэлтийн эдийн засгийг бүрдүүлэх

- Дата бодлогын хяналтын цамхаг гэсэн үүднээс "Үндэсний мэдээллийн бодлогын хороо" байгуулсан
- Төр хувийн хэвшлийн мэдээллийн платформуудын уялдаа холбоог бүрдүүлж дата аж үйлдвэрлэлийн нэгдсэн дэмжлэгийн баазыг бүрдүүлж Үндэсний хэмжээний мэдээллийн стандартчиллын тогтолцоог байгуулах

(Үйлчилгээ) “Миний мэдээлэл”-ийг бүх талбарт өргөжүүлэх

- Компанийн эзэмшиж буй хувийн мэдээлэлд хэн ч шударга ёсоор хандах, ашиглах боломжийг олгон "Миний мэдээлэл"-ийн системийг бүх талбарт өргөжүүлэх : Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг шинэчлэх, стандартчилахыг дэмжих
- Харилцаа холбоо, ажил эрхлэлт гэх мэт шинэ талбарт ялгаатай мэдээллийг нэгтгэх "Миний мэдээлэл"-ийн баталгаажуулалтыг өргөжүүлэх



04 БНСУ-ЫН МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО

1) Мэдээллийн инноваци ба үндэсний бодлого

Б. Дата аж үйлдвэрийг дэмжих ерөнхий төлөвлөгөө (2023.01.)

- "БНСУ-ын Дижитал Стратеги"-ийн дата, хиймэл оюун ухааны салбарт нэмэлт төлөвлөгөө болгон боловсруулсан энэхүү хөтөлбөр нь дэлхийн хамгийн шилдэг дата хүчирхэг улс болох алсын харааг зорьж **① мэдээллийн зах зээлийн хэмжээ 50 их наяд вон, ② мэдээллийн ашиглалтын хүчин чадлаараа эхний 10 багтах, ③ ААН мэдээлэл нэвтрүүлэх түвшин 30%. хүргэх** гэсэн 3 зорилт тавьсан.
- Дөрвөн стратеги тус бүрийн сэдэв нь дараах байдалтай байна.

Стратеги	Хэрэгүүлэх сэдэв
Дата үйлдвэрлэх, нээх, уваалцах	<ul style="list-style-type: none"> • AI зэрэг шинэ салбаруудыг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор стратегийн дата үйлдвэрлэх, хуваалцах • Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан шинэлэг мэдээлэл солилцох, ашиглах • Хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцүүлэн хуримтлагдсан олон нийтийн мэдээллийг нээнэ
Өгөгдөл түгээх ханган нийлүүлэх	<ul style="list-style-type: none"> • Дата аж үйлдвэрлэлийн экосистемийг дэмжих үндэсний нэгдсэн дэд бүтцийг бий болгох (Нэг цонх) • Шинэ дата ханган нийлүүлэх, түгээх системийг нэвтрүүлэх, нутагшуулах • Төр хувийн хэвшлийн мэдээллийн уялдаа холбоотой ашиглах стандарт хэрэгжүүлэх • Дата ханган нийлүүлэх, түгээхэд хувийн хэвшлийн оролцоог бэхжүүлэх
Дата хамгаалалт ба ашиглалт	<ul style="list-style-type: none"> • Мэдээлэл хамгаалах, ашиглалтын дүрэм журмын шинэчлэх • Тарийн мэдлийн мэдээллийн бүрэн эрхийг өргөжүүлэх • Нууц мэдээллийн системийн хэрэглээг сайжруулах • Мэдээлэл хамгаалалт, ашиглалтын дэд бүтцийг бэхжүүлэх
Мэдээллийн салбарын үндсийг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Ард иргэдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх • Үйлдвэрлэлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэдээллийн боловсон хүчнийг бэлтгэх • ААН-ийн мэдээллийн хэрэглээнд суурилсан дижитал өөрчлөлтийг дэмжих • Дэлхийн түвшний дата компаниудыг хөгжүүлэх • Нэгдүгээр зэрэглэлийн мэдээллийн дүн шинжилгээ, ашиглалтын технологийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх



04 БНСУ-ЫН МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО

1) Өгөгдлийн инноваци ба үндэсний бодлого

В. Засгийн газрын дижитал платформыг хэрэгжүүлэх төлөвлөгөө (2023.04.)

- Засгийн газар 2023 оны дөрөвдүгээр сард “Засгийн газрын дижитал платформыг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г танилцуулсан.
- Хиймэл оюун ухаан, датагаар бүтээсэн дэлхийн шилдэг дижитал платформт засгийн газрын алсын хараа нь : **① нэг засгийн газар, ② миний ухаалаг засгийн газар, ③ төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар өсөх платформ, ④ итгэл даах, найдвартай дижитал платформт засгийн газар** гэсэн 4 үндсэн стратеги зорилт тавийн ажиллаж байна.

Стратеги	Хэрэгжүүлэх сэдэв
Нэг засгийн газар	<ul style="list-style-type: none"> • Дижитал дээр суурилсан удирдлагын ерөнхий тогтолцооны шинэчлэл (Digital by Design) • Өгөгдлийн хуваалтын үндсэн шийдэл • Дижитал платформын засгийн газрын инновацийн дэд бүтцийг бүрдүүлэх
Миний ухаалаг засгийн газар	<ul style="list-style-type: none"> • Нэг цэгээс нэг хүсэлтээр дуусах нэгдсэн үйлчилгээ • Хүсэлт гаргаах шаардлагагүйгээр бүх зүйлийг хариуцах хэт хувийн үйлчилгээ. • Ард иргэд хэн ч бай хөнгөлөлт эдлэх орчиг бүрдүүлэх • Хиймэл оюун ухаан, мэдээлэлд суурилсан шинжлэх ухааны байнгын удирдлага нэвтрүүлэх • Ил тод, шударга дижитал ардчиллыг бий болгох
Төр хувийн хэвшил хамтдаа өсөх платформ	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн тулгамдсан асуудлыг илрүүлэх, шийдвэрлэхийн тулд төр, хувийн хэвшил хамтран ажилладаг хамтын ажиллагааны платформыг бий болгох • төр хувийн хэвшлийн мэдээлэл, үйлчилгээг нэгтгэх, ашиглахыг дэмжих • Дижитал давхцалаар дамжуулан хиймэл оюун ухаан болон дата үйлдвэрлэлийн салбарт квант үсрэлт хийх • GovTech компаниудын өсөлтийг дэмжих дэмжлэгийг бэхжүүлэх • Төрийн салбарт хувийн хэвшлийн сүүлийн үеийн хиймэл оюун ухааны технологийг идэвхтэй ашиглах
Итгэл даах, найдвартай дижитал платформт засгийн газар	<ul style="list-style-type: none"> • Хувийн мэдээллийн субъект, иргэдийн эрхийг бэхжүүлэх • Дижитал платформын засгийн газрын аюулгүй байдлыг хангасан хамгаалалтын системийг бий болгох



04 БНСУ-ЫН МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО

